

МОНГОЛ УЛС: АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН 2013



Implemented by **giz** Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH



DDC
338.9
M-692

АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2014

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Сан бизнес центр 9-р давхар,
Ерөнхий сайд Амарын гудамж 29,
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот,
Монгол Улс

Утас: 976-11-321927
Факс: 976-11-321926

Цахим шуудан: info@ecrc.mn
Цахим хуудас: www.ecrc.mn
Фейсбүүк хуудас: <https://www.facebook.com/ecrcmn>
Твиттер хуудас: <https://twitter.com/ursulduhchadvar>

ISBN 978-99973-63-15-2

© Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Бүтээлийг зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, ямар нэг хадгалах системд оруулахыг хориглоно.

ӨМНӨХ ҮГ



Эрхэм Танд энэ өдрийн мэнд хүргэе,

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв 2011 онд Монгол Улсын өрсөлдөх чадварын анхны бие даасан тайланг гаргаж байсан үе саяхан мэт санагдаж байна. Харин өдгөө дэлхийн бусад улс орнуудтай өөрсдийгөө харьцуулж, хөгжлийн замаа тодруулан харж байсан тэрхүү аргачлалаар улсынхаа “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан”-г хоёр дахь жилдээ гаргаж байгаад баяртай байна.

Аймгууд орон нутгаа хөгжүүлэхийн тулд бусад аймагтай харьцуулахад хаана, ямар түвшинд яваагаа мэдэж, нөхцөл байдлаа хэмжиж үзэх нь чухал. Хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол боловсронгуй болгож чадахгүй. Аймаг орон нутгийн удирдлагууд, шийдвэр гаргагчид бодлогоо тодорхойлж, ажлаа төлөвлөх, сайжруулах, ард иргэддээ бизнес эрхлэн амьжиргаагаа дээшлүүлэх боломжит орчныг нь бүрдүүлж өгөхөд энэхүү тайлан найдвартай мэдээллийн эх сурвалж болно гэдэгт итгэж байна.

Монголчууд бид өргөн уудам газар нутагтаа тархан амьдардаг ч хөгжлийн гэгээ түүний өчүүхэн хэсэг дээр л тусаж байна. Энэ улсаа нэгэн цул бие гэж үзвэл эд эс бүхэн нь эрүүл байж, өөрөөр хэлбэл зөвхөн нийслэл хот бус 21 аймаг нь ч бас өрсөлдөх чадвартай байж гэмээнэ улс орон маань бүхэлдээ хөгжингүй, өрсөлдөх чадвартай болох билээ.

Орон нутагт төсвийн эрх мэдэл хязгаарлагдмал, төвөөс хэт хамааралтай байснаас аймгаа жигд хөгжүүлэхэд хүндрэл учирч байсан нь үнэн. Харин 2013 оноос төсвийн эрх мэдлийг шилжүүлж, эрх мэдэл ард иргэд, орон нутагт очсон нь том дэвшил. Орон нутагт нээгдсэн төсвийн хөрөнгө оруулалт иргэдийн оролцоотой, оновчтой, үр ашигтай, хяналттай зарцуулагдаж төгс хэрэгжсэнээр л хөгжилд түлхэц болно. Төсвийн хөрөнгө оруулалт чухал, түүнээс чухал нь хувийн хөрөнгө оруулалт гэдгийг бас мартаж болохгүй.

Хөгжил дэвшил эх орны минь өнцөг булан бүрд адилхан хүрэх цаг үе удахгүй ирнэ гэдэгт гүнээ итгэж байна.

Танд амжилт хүсье.

Пунцагийн Цагаан

Удирдах Зөвлөлийн Тэргүүн

СУДАЛГААНЫ БАГ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Удирдах Зөвлөлийн тэргүүн П.Цагаан

Захирал Б.Лакшми

Менежер И.Одончимэг

Судалгааны багийн ахлагч Э.Тунгалаг

Судлаач Ч.Ганбат

Судлаач Д.Дэлгэржаргал

Судлаач Х.Есөнчулуу

Судлаач Х.Отгон-Эрдэнэ

www.ecrc.mn

ТАЛАРХАЛ



Аймгуудын өрсөлдөх чадварын хоёр дахь тайлантай танилцаж буй эрхэм Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ) өнгөрсөн жил анх удаа аймаг, орон нутгийн хөгжлийн түвшин, өрсөлдөх чадварыг бодитоор хэмжин үнэлэх санаачилга гарган судалгааны ажлаа эхлүүлсэн билээ.

Аливаа ажлыг эхлүүлэх нэг хэрэг ч түүнийг улам чанаржуулан үргэлжлүүлэн авч явна гэдэг бүр чухал. Аймгуудын хөгжил, өрсөлдөх чадварыг жил бүр тогтмол хэмжсэнээр түүний өөрчлөлт хөдөлгөөнийг судлах, аймгуудыг хооронд нь харьцуулахаас гадна өмнөх жилүүдтэй нь харьцуулах боломж бүрдэж байна.

Энэхүү тайланг жил бүр тогтмол боловсруулан гаргахад бидэнтэй хамтран ажиллаж дэмждэг байгууллага, хувь хүмүүсийн оролцоо туйлаас чухал билээ.

Аймаг орон нутгийнхаа өрсөлдөх чадварыг хэмжихэд туслан үнэтэй саналаа хуваалцсан орон нутгийн бизнес эрхлэгчдийн төлөөлөл, тэдний саналыг сонсох боломж олгосон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын орон нутаг дахь салбар танхимууд, тэдгээрийн хамт олонд гүн талархал илэрхийлье. Мөн тайланг хэвлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн хамт олонд талархаж байна.

Тайланг гарын авлага болгон ашиглаж бидэнтэй хамтран ажиллаж буй Танд ЭЗБӨЧСТ-ийн хамт олныхоо өмнөөс ажлын өндөр амжилт хүсье.

Боожоогийн Лакшми

Ерөнхий захирал

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД



ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага
хөтөлбөр



Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
Орон нутаг дахь салбар танхимууд



Монголын эдийн засгийн форум

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ



Үндэсний статистикийн хороо



Монголбанк

ГАРЧИГ

Товчилсон нэрсийн жагсаалт	9
ХӨГЖЛИЙН ДУУДЛАГА	10
СУДАЛГААНЫ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ.....	13
АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ.....	19
Өрсөлдөх чадварын хүчин зүйлс	20
Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ 2013.....	21
Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ	27
АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	31
СТАТИСТИК ХҮСНЭГТҮҮД.....	117
1 Эдийн засгийн тамир тэнхээ.....	119
2 Засаглалын үр ашиг.....	131
3 Бизнесийн үр ашиг	141
4 Дэд бүтэц.....	151
ХАВСРАЛТ	175
Өрсөлдөх чадвар судлалын тухай ерөнхий ойлголт.....	176
Мэдээллийн эх сурвалж, тайлбар	178

Аймгуудын өрсөлдөх чадварын төлөв байдал

АРХАНГАЙ	32
БАЯН-ӨЛГИЙ	36
БАЯНХОНГОР	40
БУЛГАН	44
ГОВЬ-АЛТАЙ	48
ГОВЬСҮМБЭР	52
ДАРХАН-УУЛ	56
ДОРНОГОВЬ	60
ДОРНОД	64
ДҮНДГОВЬ	68
ЗАВХАН	72
ОРХОН	76
ӨВӨРХАНГАЙ	80
ӨМНӨГОВЬ	84
СҮХБААТАР	88
СЭЛЭНГЭ	92
ТӨВ	96
УВС	100
ХОВД	104
ХӨВСГӨЛ	108
ХЭНТИЙ	112

Товчилсон нэрсийн жагсаалт

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
МБ	Монголбанк
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УИХ	Улсын их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

ХӨГЖЛИЙН ДУУДЛАГА

“Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан” судалгаа ийнхүү хоёр дахь жилдээ гарч буй нь орон нутгийн өрсөлдөх чадварыг хэмжих төдийгүй өөрчлөлт, хөдөлгөөнийг харах боломжийг бүрдүүлж байна. Өнгөрсөн жилийн анхны тайлангийн үр дүнгээр бид орон нутгийн хөгжлийн хоцронги байдал нь дэд бүтцийн чанар, хүртээмжтэй ихээхэн холбоотой байгааг харсан. Үүнд үндсэн дэд бүтэц (зам, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, цахилгаан)-ээс гадна зөөлөн дэд бүтэц (эрүүл мэнд, боловсрол) хамаарна. Түүнчлэн ихэнх аймагт үйлдвэржилт байхгүй, бизнесийн орчин сул хөгжсөн нь хөгжлийн чөдөр тушаа болж байв. Угаас хүн ам илүү төвлөрсөн, үйлдвэржилт эсвэл уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж буй, түүнийг дагасан бизнесийн орчин харьцангуй сайн хөгжсөн аймгууд өрсөлдөх чадвараар тэргүүлж буй нь харагдсан.

Тэгвэл үүнээс хойш нэг жилийн хугацаанд аймаг орон нутгийн хөгжлийн түвшин, өрсөлдөх чадвар хэрхэн өөрчлөгдсөн, сайжирсан эсвэл буурсан эсэхийг энэ удаагийн тайлангаас дэлгэрэнгүй харж болно.

Өрсөлдөх чадвараар Орхон, Өмнөговь, Дархан-Уул аймгууд тэргүүлсэн хэвээр байна. Өрсөлдөх чадварын ерөнхий эрэмбээр өнгөрсөн жил Дундговь аймаг сүүл мушгиж, Архангай аймаг сүүлээсээ хоёрт жагссан бол энэ жил Архангай аймаг сүүл мушгижээ. Гэхдээ өрсөлдөх чадварын онооны хувьд эдгээр аймгууд өнгөрсөн жилээс өсч амжилт үзүүлсэн. Дундговь аймгийн хувьд эдийн засаг, засаглалын үзүүлэлтээр хоцрогдолтой хэвээр байгаа ч нийслэл хоттой хатуу хүчилттай авто замаар холбогдон дэд бүтцийн үзүүлэлтээр ахиц гарч өрсөлдөх чадварын ерөнхий оноо 28-аас 43 болж өссөн байна. Архангай аймгийн хувьд мөн өрсөлдөх чадварын ерөнхий оноо нэмэгдсэн буюу 37-оос 41 болж өссөн ахицтай байна.

Аймгуудын өрсөлдөх чадварын оноо ийнхүү нэмэгдсэнээр өрсөлдөх чадвар хамгийн сайн болон өрсөлдөх чадвар сул аймгийн хоорондын онооны ялгаа багасч байна. Өөрөөр хэлбэл өрсөлдөх чадвар хамгийн сайн аймаг 100 оноотой гэж үзвэл хамгийн сул аймаг өнгөрсөн жил 28 оноо авсан байхад энэ жил 41 оноо авчээ.

Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны тайлангуудыг гаргаж буй энэ цаг үе нь төрөөс аймаг, орон нутгийн хөгжилд бодлогоор анхаарч, томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлж буйтай давхцаж байна. Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан нь эдгээр өөрчлөлтийн үр дүнг тодорхой хэмжээгээр хэмжих, орон нутгийн хөгжлийн үйл явцтай хөл зэрэгцэн сонирхолтой өөрчлөлтүүдийг харуулах нөхцөл бүрдэж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газар 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө “Аюулгүй орчинтой монгол хүн” зорилтын хүрээнд Аймгийн төвийг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх зорилго тавин ажиллаж байна. 2013 оноос аймгийн төсвийн эрх мэдэл нэмэгдэж, орон нутгийн хөгжлийн сан бий боллоо.

Дээрх төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг одоогоор үнэлэхэд эрт байгаа ч жил бүр боловсруулагдан гарах энэхүү судалгааны үр дүнгээс олон өөрчлөлтийг харж болно.

Орон нутгийн өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд хийх ажил их байна. Энэ удаагийн тайлангийн үр дүнгээс харахад хөдөө, орон нутгийн хөгжлийг хойш татаж буй гол хүчин зүйлс нь аймгийн хөгжлийн бодлогыг урт хугацаанд тодорхойлох, дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулахтай холбоотой асуудлууд хэвээр байгаа бөгөөд өрсөлдөх чадварын тогтвортой ахиц бий болгохын тулд бодлогын хүрээнд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн бодлого, зорилтуудыг оновчтой тодорхойлох

Аймаг бүр өөрийн гэсэн хөгжлийн бодлоготой байдаг ч илүү урт хугацааны, тухайн аймгийн онцлогт тохирсон, өрсөлдөх чадварын давуу талд тулгуурласан хөгжлийн бодлого үгүйлэгдэж байна. Ялангуяа орон нутагт төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж буй энэ цаг үед төсвийг хэрхэн үр ашигтай зарцуулах, орон нутгийн хөгжлийг хангах оновчтой бодлого хэрэгжүүлэх нь чухал.

2013 оны Улсын төсөвт орон нутгийн төсөв санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулах алхамуудыг хэрэгжүүлж эхэлснээр

орон нутгийн төсвийн нийт орлого 1,828.9 тэрбум төгрөг болж, 2012 онд улсын төсвийн 9.0 хувийг эзэлж байсан орон нутгийн төсөв даруй 2.3 дахин нэмэгдэж, 20.7 хувийг эзлэх болоод байна. Түүнчлэн энэ оноос орон нутгийн хөгжлийг дэмжих “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”-г байгуулж, аймаг, сум тус бүр өөрийн орон нутгийн хөгжлийн сантай боллоо. Уг сангаас 2013 онд нийтдээ 247.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан. Аймгуудын төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж буй нь сайн хэрэг ч энэхүү төсвийг хэрхэн үр ашигтай зарцуулах талаар бодит судалгаа, зөвлөмж дутмаг байна.

Өргөн уудам газар нутагтай манай орны 21 аймаг тус бүр газарзүйн нөхцөл байдал, цаг уур, эдийн засгийн түвшин зэргээс шалтгаалаад өөр хоорондоо ялгаатай, өөрийн гэсэн давуу тал, боломжуудтай байдаг. Тиймээс тухайн орон нутгийн давуу талд тулгуурласан хөгжлийн урт хугацааны бодлогыг оновчтой хэрэгжүүлэх шаардлагатай.

Өрсөлдөх чадварын үндсэн зарчим нь аливаа улс, эсвэл аймаг өөрийн давуу талаа үнэлэн тодорхойлж, түүндээ тулгуурлан тогтвортой хөгжлийг бий болгоход оршдог. Мал аж ахуй түлхүү хөгжсөн бол түүнийг нь улам хөгжүүлэх, фермерийн аж ахуй, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэл бий болгох, газар тариалан хөгжүүлэх боломжтой бол илүү дэвшилт технологи бүхий газар тариалангийн үйлдвэрлэл бий болгох, байгалийн үзэсгэлэнт газартаа түшиглэн дотоодын болон гадаадын аялал жуулчлалыг цогц байдлаар хөгжүүлэх гэх мэтээр ялгаатай болон хосолсон бодлогуудыг боловсруулж тухайн аймаг, тухайн бүсэд тохирсон салбарыг сонгон хөгжүүлэх нь чухал. Үүнд урт хугацааны зорилт, хөтөлбөр, хөгжлийн бодлого зайлшгүй шаардлагатай.

2. Дэд бүтцийг хөгжүүлэх

Аймгийн хөгжил ямар түвшинд байгаа нь юун түрүүн тэнд амьдарч буй ард иргэдийн амьдрах таатай орчин хэрхэн бүрэлдсэн, амьдарч буй газар нутгаас үл хамааран эрүүл мэнд, боловсролын болон бусад нийгмийн үйлчилгээг чанартайгаар хүртэж чадаж буй эсэхээр хэмжигдэнэ. Одоогийн байдлаар аймаг бүрт ийм нөхцөл хараахан бүрдэж амжаагүй явна. Гэхдээ тодорхой хэмжээний ахиц дэвшил гарч, дэд бүтцийн үзүүлэлтээрх өрсөлдөх чадварын

онооны хувьд ихээхэн өөрчлөлт гарчээ.

Одоогийн байдлаар Монгол Улсын 21 аймгийн тал орчим нь буюу 12 нь нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдоод байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу аймгийн төвүүдийг Нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох ажлын хүрээнд 2013 онд нийт 1560 км авто замын ажлыг шинээр гүйцэтгэсэн ба үүнд Дундговь, Дорноговь, Баянхонгор аймгуудад хийсэн бүтээн байгуулалтыг дурьдаж болно. Түүнчлэн 2014 онд Зам тээврийн сайд А.Гансүхын мэдээлснээр 2200 км авто зам барих бөгөөд Хөвсгөл, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Говь-Алтай, Завхан аймгийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбохоор төлөвлөжээ. 2015 онд Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад замын ажлыг гүйцэтгэснээр Монгол Улсын 21 аймаг нийслэл хоттойгоо хатуу хучилттай авто замаар бүрэн холбогдох аж.

Зам бол хөгжлийг түгээх гол судас. Ямартаа ч 2015 он гэхэд 21 аймгийн төвийг Улаанбаатар хоттойгоо холбочихвол орон нутгийн хөгжлийн түвшинд тодорхой ахиц гарах нь дамжиггүй.

Үүнээс гадна цахилгаан, дулаан, цэвэр усны хангамжийн асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай. Засгийн газрын “Аймгийн төв бүрийг хот болгох” бодлогын хүрээнд дэд бүтцийн асуудлуудыг авч үзэж байгаа ч энэ нь үе шаттайгаар хэрэгжих, тодорхой хугацаа шаардах ажлууд юм. Сумдыг хөгжүүлэх “Шинэ сум төсөл”¹ 2013 онд албан ёсоор гурван сум буюу Баянхонгор аймгийн Баянлиг, Бууцагаан, Дорноговь аймгийн Замын-Үүд сумдаас түүчээлэн барилгын ажил явагдаж байна.

Энэ төсөл нь Улаанбаатар хот болон аймгийн төврүү шилжих хөдөлгөөнийг сааруулах, сумдын дэд бүтцийг сайжруулах хүлээлтийг үүсгээд байна.

3. Бизнесийн орчныг сайжруулах

Монгол Улсад нийт 45 мянган хувийн хэвшлийн аж ахуйн нэгж бүртгэлтэй байдгаас 70 хувь нь

¹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 06 сарын 25-ны өдрийн тогтоолоор “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр баталж, үүнд хөдөөгийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд “Сум дундын төв” загвар төслийг хэрэгжүүлэхээр заасан. Төслийн гол зорилго нь нэгдсэн стандартаар сумдын төвд төрийн үйлчилгээний цогцолбор (дэд бүтцийн нэгдсэн шугам сүлжээ бүхий нутгийн захиргааны байгууллага, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, соёл, спортын төв) байгуулах юм. Төслийн үе шат нь дараах байдлаар хэрэгжинэ. Үүнд:

- 2012-2014 буюу I шат, 5 сум
- 2014-2015 буюу II шат, 13 сум
- 2015-2016 буюу III шат, 78 сум

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 15 мянга орчим аж ахуйн нэгж буюу жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлөөлөл тэдэнд тулгардаг хамгийн том асуудлыг бизнесээ өргөжүүлэн тэлэх хөрөнгө оруулалт, санхүүжилт олох боломж хязгаарлагдмал байдаг хэмээн тодорхойлж байна.

Судалгааны хүрээнд бизнес эрхлэгчдээс авсан санал асуулгын үр дүнгээр Бизнесийн таатай орчин үзүүлэлтээр 10 онооноос хамгийн өндөр оноог Сүхбаатар аймаг авчээ. Орон нутгийн бизнесийн орчныг хамгийн сайндаа 10 онооноос 5.8 оноогоор үнэлж байна. Орхон аймаг 5.5 оноогоор, Сэлэнгэ аймаг 5.3 оноогоор тус тус удаалсан байна. Өнгөрсөн жил энэ үзүүлэлтээр 6.2 оноо авч тэргүүлж байсан Өмнөговь аймаг энэ жил 4.7 оноо авсан байна. Харин Дундговь аймаг 3.3 оноогоор сүүл мушгижээ.

Бизнес эрхлэгчид зээл авахад хэр хялбар байдаг үзүүлэлтээр хамгийн өндөр нь Орхон аймаг 6.3 оноо авсан байна. Жижиг, дунд бизнес эрхлэгчид зүгээр бэлэн мөнгө авахыг хүсдэггүй, харин тэдний одоогийн нөхцөл байдалд тохируулан барьцаа хөрөнгийн шалгуур, зээлийн хүүг хөнгөлөлттэй байдлаар шийдвэрлэж өгөхийг хүсэж байна. Түүнээс гадна орон нутгийн хөгжил, газарзүйн байршил, хүн амын нягтралтай уялдуулан татварын ялгаатай бодлого хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байв.

Эдгээрээс гадна орон нутагт бизнесийн орчныг сайжруулахын тулд юун түрүүн хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулах, орон нутагт иргэд ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлж, зах зээлийг тэлэх шаардлагатай. Учир нь орон нутагт бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нь худалдан авах зах зээл хийгээд, мэргэшсэн ажиллах хүч зайлшгүй шаардлагатай байдаг.

2014 оны 1 дүгээр сарын 18-ны Засгийн газрын хуралдаанаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн, УИХ-д

өргөн барихаар болоод байна. Шинэ хуулиар НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босгыг бууруулж буй аж. Одоогийн мөрдөгдөж буй хуулиар борлуулалтын орлого 10 сая төгрөгөөс дээш аж ахуйн нэгжүүд НӨАТ төлөгч болдог байсан бол үүнийг 50 сая төгрөг болгон бууруулахаар төсөлд тусгажээ. Ингэснээр татвар төлөгч жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 50 орчим хувь нь ийм төрлийн татвараас чөлөөлөгдөх аж.

Энэ нь тодорхой хэмжээгээр бизнес эрхлэгчдэд учирч буй дарамтыг бууруулна гэж үзэж байна.


Дүгнэлтийн оронд

Гар хөдөлбөл ам тосдоно гэдэг. Ямартаа ч төрийн зүгээс хөдөөд чиглэсэн олон төслүүдийг хэрэгжүүлж, аймаг орон нутгийн хөгжил бага гэлтгүй өдрөөс өдөрт сайжирсаар байна. Гэхдээ хөгжлийг улам хурдасгах, дэлхий дахинтай биш юмаа гэхэд нийслэл хоттойгоо хөл нийлүүлэн алхахын тулд хийх ажил их байна. Дээр дурьдсан орон нутгийн хөгжлийн бодлого, дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулах нь хамгийн чухал асуудлууд бөгөөд үүнтэй зэрэгцэн одооноос анхаарч эхлэх шаардлагатай асуудлууд мөн байна.

Орон нутгийн хүн ам ихэвчлэн аймгийн төвдөө төвлөрдөг бөгөөд энэ нь тодорхой хэмжээгээр хүн амын бөөгнөрөл, хотжилтод тулгардаг асуудлуудыг дагуулж байна. Зарим аймгийн төвүүдийн хүн амын төвлөрлийг сааруулах, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, хог, ногоон байгууламж болоод аймгийн төвийн агаарын бохирдлын асуудлыг одооноос анхаарах нь зүйтэй.

Ямартаа ч орон нутгийн хөгжилд бодлогоор анхаарч эхэлж буй энэ цаг үед аймгийн удирдлагууд илүү санаачлагатай, хариуцлагатай ажиллаж, боломжуудыг ашиглах нь чухал.

Хоёр дахь удаагаа боловсруулагдан гарч буй энэхүү тайлангаас аймаг, орон нутгийн удирдлагууд олон олон шинэ санаа, шийдлийг тусган авна гэдэгт итгэлтэй байна.



СУДАЛГААНЫ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ

Судалгааны зорилго, ач холбогдол

Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны зорилго нь Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн өнөөгийн түвшинг харьцуулан үнэлэх, аймгуудын өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлоход оршино. Судалгаагаар аймаг бүрийн хөгжлийн давуу ба сул талыг тодорхойлж, өрсөлдөх чадварын боломж, чадавхийг үнэлэн тогтвортой, урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулахад ашиглахуйц өргөн хүрээний мэдээллийн сан бүрдүүлнэ.

Аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулж, өрсөлдөх чадварын чиг хандлагыг тодорхойлохоос гадна тухайн аймгийн өрсөлдөх чадварыг хойш татаж буй эсвэл дээшлүүлж буй үзүүлэлтүүдийг тогтоож, өрсөлдөх чадварын давуу, сул талыг үнэлэх боломж олгож буй нь энэхүү судалгааны давуу тал юм. Ингэснээр аль аймаг яагаад өрсөлдөх чадварын хувьд бусдаас сайн, эсвэл сул байгааг ойлгож мэдэх, тухайн аймаг давуу талаа хэрхэн ашиглаж болох, хөгжлийг хойш татаж буй сул талаа хэрхэн шийдвэрлэх шийдлийг олоход чухал эх үүсвэр болох юм.

Өрсөлдөх чадварын талаарх ойлголт нь харьцангуй шинэлэг бөгөөд бусдаас давуу байдлыг судлахаас илүүтэй тухайн улс, аймаг өөрийн нөөц боломжоо хэрхэн үр дүнтэй ашиглаж, өөрийн гэсэн өрсөлдөх чадварыг бий болгож, амьдрах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж чадсан эсэхийг судалдаг. Тиймээс ч бид аливаа аймаг өөрийн өрсөлдөх чадварыг дэмжин хадгалах таатай орчныг бүрдүүлж чадсан эсэх, түүнийгээ тордон сайжруулж буй байдлыг дүгнэж, бусад аймагтай харьцуулан эрэмбэлсэн. Өөрөөр хэлбэл, тухайн аймаг өөрийн нөөц, боломж, онцлог давуу талаа

зохистой удирдаж, аж ахуйн нэгжүүдээ бүтээмж өндөртэй ажиллах, ард иргэдээ чинээлэг хангалуун амьдрах боломжоор хангаж чадаж байна уу? гэдэгт энэхүү тайлан хариулт өгч байна.

Дашрамд дурдахад, уг судалгаа нь аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулан судалж буй тул өрсөлдөх чадвараараа тэргүүлсэн аймгуудыг өрсөлдөх чадвар сайтай гэж ойлгож болохгүй. Харин тэдгээр аймаг өрсөлдөх чадвараараа бусдаас харьцангуй илүү байгаа ч өөрийн өрсөлдөх чадварын сул үзүүлэлтүүдийг сайжруулах, давуу талаа ашиглан илүү хурдтай хөгжих хэрэгтэйг харуулна. Үүний адилаар өрсөлдөх чадвараар сүүл мушгисан аймгуудын хувьд ч тухайн аймгууд өрсөлдөх чадвар муутай гэхээс илүү бусад аймагтай харьцуулахад өрсөлдөх чадвараар сул байна хэмээн ойлгож, бусад аймгаас хэрхэн суралцах, өөрийн өрсөлдөх чадварыг ямар үзүүлэлтүүд хойш татаж буйг тодорхойлж, тэдгээрийг сайжруулахад анхаарах нь зүйтэй.

Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан нь бодлого боловсруулагчдын хувьд аймгуудын өнөөгийн хөгжлийн түвшин, нөхцөл байдлыг бодитоор харж, орон нутгийг хөгжүүлэхэд чиглэсэн илүү үр ашиг бүхий шийдвэр гаргахад тус болохуйц мэдээллийн эх үүсвэр, гарын авлага байх юм. Түүнчлэн аймгийн удирдлагууд өөрийн бодлого шийдвэрүүдийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, бусад аймагтай харьцуулах, туршлага судлах боломжтой болж буй. Мөн ажил хэрэгч хүмүүс бизнесийн болон хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргахдаа орон нутгийн талаарх найдвартай бөгөөд цогц мэдээллийг энэхүү тайлангаас авч болох билээ.

Аймгуудын өрсөлдөх чадварыг хэмжих үзүүлэлтүүд

Аймгуудын өрсөлдөх чадварыг зөвхөн ДНБ-ий хэмжээ, ажилгүйдлийн түвшин төдийгөөр хэмжин харьцуулах боломжгүй. Учир нь тухайн аймгийн бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа, иргэдийн амьжиргаанд эдийн засаг, улс төр, нийгмийн болон соёлын гэх мэт олон хүчин зүйл нөлөөлж байдаг.

Энэхүү судалгааны хүрээнд аймгуудын өрсөлдөх чадварыг үнэлэн эрэмбэлэхдээ Дэлхийн өрсөлдөх чадварын төвтэй хамтран гаргадаг Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан судалгааны аргачлалын дагуу 4 бүлэг үзүүлэлтээр хэмжсэн ба аймгуудын онцлог шинжийг тусгах, илүү дэлгэрэнгүй харьцуулалт хийх үүднээс бүлэг доторх шалгуур үзүүлэлтүүдийг өөрчлөн тохируулсан болно.

Эдийн засгийн тамир тэнхээ, Засаглалын үр ашиг, Бизнесийн үр ашиг, Дэд бүтэц гэсэн үндсэн 4 бүлэг, тэдгээрийг нарийвчлан үнэлэх тус бүр 4 дэд бүлэг буюу нийт 16 дэд бүлгийн хүрээнд аймгуудын өрсөлдөх чадварыг олон талаас нь тодотгон харуулах 180 шалгуур үзүүлэлт ашиглалаа.

Эдийн засгийн тамир тэнхээ бүлэгт тухайн аймгийн эдийн засгийн ерөнхий байдлыг макро эдийн засаг, эдийн засгийн салбаруудын хөгжил, хүн амын амьжиргааны түвшин, хөдөлмөр эрхлэлт гэсэн 4 дэд бүлэг, нийт 38 шалгуур үзүүлэлтээр хэмжсэн.

Засаглалын үр ашиг бүлэгт өрсөлдөх чадварыг дэмжих аймгийн удирдлагын бодлого шийдвэр, түүний цар хүрээг аймгийн төсөв, институцийн тогтолцоо, бизнесийн эрхзүй, нийгмийн тогтолцоо гэсэн 4 бүлэг бүхий 30 шалгуур үзүүлэлтээр нарийвчлан үнэлсэн болно.

Бизнесийн үр ашиг бүлэгт аймгийн бизнесийн байгууллагуудын үр ашигтай, хариуцлагатай, шинэлэг үйл ажиллагаа явуулах чадамжийг судлахын тулд бизнесийн орчин, хөдөлмөрийн зах зээл, бүтээмж, санхүү, менежментийн хэвшил гэсэн 4 дэд бүлэг, 30 шалгуур үзүүлэлт ашиглав.

Бизнесийн хэрэгцээг хангах, ард иргэдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулах дэд бүтцийн хөгжлийг үндсэн дэд бүтэц, технологийн дэд бүтэц, шинжлэх ухаан, боловсрол, соёл ба эрүүл мэнд, хүрээлэн буй орчин гэсэн 4 дэд бүлгийн хүрээнд 82 шалгуур үзүүлэлтээр тодорхойллоо.

Ийнхүү аймгуудын өрсөлдөх чадварыг нийт 180 шалгуур үзүүлэлтээр хэмжсэн бөгөөд энэ нь өрсөлдөх чадварыг тал бүрээс нь илүү тодорхой үнэлэх боломж олгож, аль нэг үзүүлэлт ташаа ойлгогдохоос сэргийлэх ач холбогдолтой буюу аль нэг үзүүлэлтийн ерөнхий үнэлгээнд үзүүлэх нөлөө хязгаарлагдмал байна. Эдгээр үзүүлэлтийг аймгуудын түвшинд, 21 аймаг тус бүрээр гаргаж өрсөлдөх чадварын индекс, эрэмбийг тооцсон болно.

Эдийн засгийн тамир тэнхээ	Засаглалын үр ашиг	Бизнесийн үр ашиг	Дэд бүтэц
<ul style="list-style-type: none"> Эдийн засаг Эдийн засгийн салбарууд Хүн амын амьжиргааны түвшин Хөдөлмөр эрхлэлт 	<ul style="list-style-type: none"> Аймгийн төсөв Институцийн тогтолцоо Бизнесийн эрхзүй Нийгмийн тогтолцоо 	<ul style="list-style-type: none"> Бизнесийн орчин Хөдөлмөрийн зах зээл, бүтээмж Санхүү Менежментийн хэвшил 	<ul style="list-style-type: none"> Үндсэн дэд бүтэц Технологийн дэд бүтэц Шинжлэх ухаан, боловсрол, соёл Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин

Мэдээллийн эх үүсвэр

Аймгуудын өрсөлдөх чадварын судалгаа нь дээр тодорхойлсон өрсөлдөх чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийг хоёр төрлийн эх үүсвэрээс бүрдүүлсэн. Үүнд:

- Статистик мэдээлэл
- Удирдах ажилтны санал асуулга

Аймгуудын өрсөлдөх чадварыг үнэлэх нийт 180 шалгуур үзүүлэлтийн ойролцоогоор 2/3 нь буюу 116 нь статистик мэдээлэл, 1/3 нь буюу 64 нь санал асуулгын мэдээлэл байна. Статистик мэдээллийн 25 хувь буюу 30 нь ерөнхий мэдээлэл байх ба өрсөлдөх чадварын индексийн тооцооллд ордоггүй, нэмэлт мэдээлэл өгөх зорилготой үзүүлэлтүүд юм.

Статистик мэдээлэл нь өрсөлдөх чадварыг тодорхой хугацаанд (өнгөрсөн 1 жилд гэх мэт) хэмжиж харуулдаг ба өрсөлдөх чадвар ямар түвшинд байгааг (жишээ нь ДНБ-ий хувьд) илэрхийлдэг. Харин санал асуулгаар шууд хэмжихэд бэрх тоон бус үзүүлэлтүүдийг тодорхойлж, статистик үзүүлэлтээр хэмжих боломжгүй мэдээллүүдийг олж авдаг онцлогтой. Түүнчлэн санал асуулгын мэдээлэл нь тухайн статистик мэдээллүүдийг батлах, бодит байдлыг тодруулах, иргэд, хувийн хэвшлийнхэн тухайн үзүүлэлтийг хэрхэн үнэлж буйг харуулах ач холбогдолтой. Тиймээс “өнгөрсний дүр зураг” болдог статистик тоон үзүүлэлттэй харьцуулахад санал асуулга нь бодит байдалд илүү дөхөм, цаг хугацааны хувьд илүү шинэлэг байдаг.

Удирдах ажилтны санал асуулга

Удирдах ажилтны санал асуулгад хувийн хэвшлийн төлөөлөл буюу аймагт үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагын дунд болон

дээд шатны удирдах ажилтнууд хамрагддаг ба тухайн аймаг дахь бизнес эрхлэх таатай орчин, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн талаарх тэдний ойлголт, тухайн орчин дахь нөхцөл байдлыг бодитоор хэрхэн үнэлж буйг судалдаг.

Санал асуулгад оролцогч удирдах ажилтнууд туршлагатай, үйл ажиллагаа явуулж буй орчноо гүнзгий мэддэг зэргээс хамааран нийгэм, эдийн засгийн орчин, өрсөлдөх чадварын нөхцөл байдалд илүү бодитой үнэлэлт, дүгнэлт өгч чадна гэж бид үздэг.

Удирдах ажилтны санал асуулгын түүвэр судалгаанд Монгол Улсын 21 аймгийн бизнесийн байгууллагын удирдах ажилтнуудыг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгож хамруулсан. Түүврийн хэмжээг энгийн санамсаргүй, буцаалтгүй түүврийн аргаар тодорхойлж, аймгуудын түүврийн бүтцийг хүн амын тоотой пропорциональ хэлбэрээр сонгож авсан. Түүврийн бус алдаа гарахаас сэргийлэх үүднээс түүврийн зайлшгүй хэмжээг томруулан аймаг бүрээс дунджаар 25 удирдах ажилтан, нийт 525 оролцогчтойгоор түүвэр судалгааг явуулсан.

Санал асуулга нь нийт 64 хаалттай асуулт, 1 нээлтэй асуултаас бүрдэх ба судалгаанд оролцогчид хаалттай асуултуудад 1-6 хүртэлх шатлалтай хариултаас өөрийн санал хамгийн ихээр нийцэх үнэлгээг сонгох замаар байр сууриа илэрхийлнэ. 1-3 хүртэлх хариулт нь тухайн асуудлыг үнэлэх дүгнэлт сөрөг байгааг, 4-6 хүртэлх нь эерэг байгааг илтгэнэ. Нийт хариултаас үзүүлэлт бүрээр, аймаг тус бүрийн дундаж үнэлгээг тооцож, улмаар өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээг тооцоход ашиглана.

Өрсөлдөх чадварын индекс, эрэмбэ тооцох аргачлал

Өрсөлдөх чадварын индекс тооцож, эрэмбэлэхдээ нийт 180 үзүүлэлтээс 150-ийг ашигласан ба (ерөнхий мэдээлэл болох 30 үзүүлэлт тооцоонд орохгүй) ба дараах алхмуудын дагуу тооцоолол хийгдсэн. Үүнд:

1. Стандартчилсан үнэлгээг тооцох

Өрсөлдөх чадварын индекс тооцох, эрэмбэлэх үндсэн суурь элемент нь үзүүлэлт бүрээр тооцсон стандартчилсан үнэлгээ юм. Энэ нь статистикийн мэдээлэл, санал асуулгын дүнгээр олж авсан ялгаатай хэмжигдэхүүн бүхий тоон мэдээллүүдийг харьцуулж болохуйц нэг төрлийн болгох ач холбогдолтой.

Стандартчилсан үнэлгээг үзүүлэлт бүрээр, аймаг бүрийн хувьд дараах томъёогоор тооцно.

$$STD(x) = \frac{x^i - \mu}{\sigma}$$

Энд:

x^i – i аймгийн шалгуур үзүүлэлт,

μ – x утгын дундаж

σ – x утгын стандарт хазайлт

Санал асуулгын хувьд 1-6 оноогоор үнэлсэн хариултуудыг 0-10 гэсэн шатлалд хөрвүүлсний дараа стандартчилсан үнэлгээг тооцно. Түүнээс гадна стандартчилсан үнэлгээг тооцоолохын өмнө үзүүлэлт бүрийн тархалтын хэлбэрийг тодорхойлж, хэвийн бус тархалттай тохиолдолд логарифм авсан утгаас стандартчилсан үнэлгээг тооцсон болно.

Стандартчилсан үнэлгээ өндөр байх тусам тухайн үзүүлэлт өрсөлдөх чадварт эергээр нөлөөлж буйг илтгэх боловч зарим үзүүлэлтийн хувьд утгыг нь бууруулах тусам өрсөлдөх чадварт илүү эерэг нөлөө үзүүлдэг тохиолдол бий. Жишээ нь, ядуурлын түвшин, эхийн эндэгдлийн түвшин гэх мэт үзүүлэлтийн стандартчилсан үнэлгээ бага байх тусам сайн. Тиймээс ийм төрлийн үзүүлэлтүүдийн хувьд стандартчилсан үнэлгээг (-1) –ээр үржүүлж тооцсон.

2. Үзүүлэлтүүдийг эрэмбэлэх

Тооцоонд хамрагдах 150 үзүүлэлт бүрийн стандартчилсан үнэлгээний энгийн дунджаар аймгуудыг эрэмбэлэнэ. Стандартчилсан үнэлгээ өндөр байх тусам өрсөлдөх чадвар сайтай байх буюу дээгүүр эрэмбэлэгдэнэ.

3. Өрсөлдөх чадварын индекс тооцох, эрэмбэлэх

Үндсэн 4 бүлэг нь тус бүр 4 дэд бүлэгт хуваагдах бөгөөд стандартчилсан үнэлгээнд тулгуурлан эдгээр 16 дэд бүлэг тус бүрийн дундаж стандартчилсан үнэлгээг аймаг бүрээр тооцох ба жигнэсэн дундаж ашиглана. Учир нь дэд бүлэг доторх үзүүлэлтийн тоо ялгаатай байх бөгөөд судалгааны үр дүнг бодитой, тэнцвэртэй байлгах үүднээс дэд бүлэг бүрийн эзлэх жинг дотроо хэдэн үзүүлэлттэйгээс үл хамааран тэнцүү ($16 \times 6.25\% = 100\%$) хэмжээтэй сонгоно. Ингэснээр дэд бүлгийн эзлэх жинг тогтмол барих боломжийг олгох төдийгүй статистик мэдээлэл дутуу, алдаатай тохиолдолд бусад бүлэгт нөлөөлөх боломжийг хааж, нийт үр дүнгийн найдвартай байдлыг өсгөдөг.

16 дэд бүлгээр тооцсон аймгуудын дундаж стандартчилсан үнэлгээнд суурилан 16 бүлгийн өрсөлдөх чадварын индексийг аймаг бүрээр дараах ерөнхий томъёогоор тооцоолно.

$$I = \frac{STD(x) - STD_{min}(x)}{STD_{max}(x) - STD_{min}(x)}$$

Энд:

I – өрсөлдөх чадварын индекс

$STD(x)$ – шалгуур үзүүлэлтийн стандарт үнэлгээ
 $STD_{min}(x)$ - шалгуур үзүүлэлтийн стандарт үнэлгээний хамгийн бага утга

$STD_{max}(x)$ - шалгуур үзүүлэлтийн стандарт үнэлгээний хамгийн их утга

Өрсөлдөх чадварын 4 ерөнхий бүлгийн индексийг дэд бүлгүүдийн индексийн энгийн дунджаар, нэгдсэн индексийг 4 бүлгийн энгийн дунджаар тус тус тооцоолно.

4 бүлгийн индекс болон нэгдсэн индексийн дүнгээр аймгуудыг эрэмбэлэх ба индексийн утга хамгийн өндөр аймгийг 100 гэж тооцон аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээг оноогоор илэрхийлж, утгын дарааллаар аймгуудыг эрэмбэлэнэ.

Ерөнхий үнэлгээний эрэмбэ нь тухайн аймгийн өрсөлдөх чадварын байр суурь бусад аймагтай харьцуулахад ямар байгааг харуулдаг. Өөрөөр хэлбэл өрсөлдөх чадвараар хамгийн дээгүүр эрэмбэлэгдсэн аймгийн хувьд тухайн аймаг өрсөлдөх чадвартай гэж тодорхойлохоос илүү тухайн аймаг бусад аймагтай харьцуулахад өрсөлдөх чадвар сайтай гэж ойлгох нь зүйтэй юм.

Аймгуудын өрсөлдөх чадварын тайланг хэрхэн ашиглах вэ?

Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээг дараах ерөнхий хэсгүүдээс харах боломжтой. Үүнд:

1. Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээ (21-32 хуудас)

Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээ нь 21 аймгийн нэгтгэсэн эрэмбэлэлээс тодорхой харагдана. Аймгууд өрсөлдөх чадвар хамгийн сайтайгаасаа эхлэн эрэмбэлэгдэнэ.

Өрсөлдөх чадварын ерөнхий ба үндсэн хүчин зүйлсийн эрэмбэ

Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээнээс гадна өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйлс болох эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц тус бүрээр өрсөлдөх чадварын үнэлгээг харж болно.

Өрсөлдөх чадварын дэд хүчин зүйлсийн эрэмбэ

Өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйл бүрийн 4 дэд хүчин зүйл буюу нийт 16 дэд хүчин зүйлийн эрэмбийг энэ хэсэгт багтаасан. Дэд бүлгүүдийн эрэмбэ нь тухайн үндсэн бүлэг бүрийн эрэмбийг илүү тодруулан, нарийвчлан харуулах юм.

Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ

Энэ хэсэгт аймаг бүрийн өрсөлдөх чадварын үндсэн 4 хүчин зүйлийн үнэлгээг 21 аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулан харуулна. Торон графикийн тусламжтайгаар тухайн аймаг ямар үзүүлэлтээр илт давуу болон сул талтай болохыг харах боломжтой.

2. Аймгуудын өрсөлдөх чадварын төлөв байдал (33-117 хуудас)

Энэ бүлэгт аймаг тус бүрийн эдийн засгийн ерөнхий байдал, өрсөлдөх чадварын амжилтын

хүрээ, өрсөлдөх чадварын дэд хүчин зүйлсийн эрэмбэ, тухайн аймгийн хөгжилд тулгарч буй саад бэрхшээл, шийдвэрлэх асуудлыг нэгтгэн харуулсан.

Түүнчлэн өрсөлдөх чадварын 4 үндсэн хүчин зүйл болох эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц тус бүрийн 10 сул болон 10 давуу талыг тодотгон үзүүлсэн. Аймгийн эдийн засгийн орчин, ирээдүйн хөгжилд ач холбогдолтой өрсөлдөх чадварын давуу болон сул талыг тогтоох нь тун чухал. Учир нь тухайн аймаг өөрийн өрсөлдөх чадварын хамгийн сайн, давуу талдаа тулгуурлан хөгжиж, баялгийг бүтээдэг. Түүнчлэн давуу талаа ашиглахын зэрэгцээ сул талаа хянаж, сайжруулах нь аймгуудын өрсөлдөх чадварыг сайжруулахад түлхэц болно.

Мөн аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулахаас гадна Өрсөлдөх чадварын хувьсал хэсгээс тухайн аймгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтийг өмнөх жилтэй нь харьцуулсан 25 өсөлт, 25 бууралтыг харах боломжтой.

3. Статистик хүснэгт (79-136 хуудас)

Энэ хэсэгт өрсөлдөх чадварын хүчин зүйлсийг тодорхойлж буй шалгуур үзүүлэлтийг дэлгэрэнгүй багтаасан. Эндээс өрсөлдөх чадварт нөлөөлж буй 150 шалгуур үзүүлэлт бүрийн эрэмбэ, мэдээллийг харж болно.

АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

Өрсөлдөх чадварын хүчин зүйлс

